

СУРАГЧДАД ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХОД ЭЭЛЖИТ ХИЧЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮҮРЭГ

Р. Туяа

Резюме

Оценка всегда влияет на стандарт учения и методику, чтобы усовершенствовать её постоянно требуется обновлять и усовершенствовать, которая показывает продвижение и перемену в технологии преподавания. Поэтому в настоящее время педагог Должен правильно направить и дать хорошее знание урока по технологию, которая успешно скажется на успеваемости учеников. Если мы сможем это дать ученикам, то они отлично усвоят урок жизни и экономическое образование.

Түлхүүр үг: Эдийн засгийн боловсрол, технологийн боловсрол, сургалт, үнэлгээ

Удиртгал

Технологийн боловсролын асуудлыг бүх шатны сургуулиар дамжуулан сургалтын зөв агуулга бүхий хөтөлбөрөөр тодорхой үе шат, зохион байгуулалттайгаар олгож байгаа ч үр дүн нь улс орнуудын хөгжлийн түвшингээс хамааран өөр өөрөөр тодорхойлогддог. Манай оронд 2004 оноос батлан хэрэгжүүлж байгаа технологийн боловсролын стандарт нь ЕБС-ийн сурагчдын нас бие сэтгэхүйн онцлогт тохирсон, технологийн боловсрол олгох хэрэгцээ, зорилго агуулгад нийцсэн баримт бичиг болсон. Сүүлийн үед сургалтыг зохион байгуулснаар сурагч төвтэй байх сургалтын зарчмыг баримтлан хүн бүрийн сурах чадвар өөр байдаг нь илүү тодорхой болж, суралцагсдыг өөр хооронд нь харьцуулах, тэднийг хэрхэн ахиж буй ахицыг тодорхойлоход нь чухал болсон юм (5). Үнэлгээнд өдөр тутмын ээлжит хичээлийн үнэлгээ чухал үүрэгтэй байх нь тодорхой юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

Технологийн хичээл нь бусад төрлийн хичээлээс судлагдахууны агуулгын хувьд өргөн хүрээгээр явагддаг, суралцагсдад танин мэдэх үйл ажиллагаа, зохион бүтээх үйл, техник технологийн мэдлэг дадлага чадвар төлөвшүүлдэг. Өнөөдөр багш сургалтын Дэвшилтэт арга хэлбэрийг ашиглан хичээлийн үр өгөөжийг дээшлүүлж суралцагчдын сонирхол идэвхийг өрнүүлж хөгжүүлж байна. Харин явуулж буй сургалтынхаа үр дүнг сайн тодорхойлж суралцагчдын чадамжийн ахицыг оновчтой тодорхойлоход учир дутагдалтай байгаа нь нууц биш юм. Энэ нь багш ээлжит

хичээл дээрээ сурагчдыг оновчтой зөв үнэлж дүгнэж чадахгүй байна гэсэн үг юм. Бид аливаа ээлжит хичээл нь орц / хичээлийн бэлтгэл үе/, явц / хичээлийн үйл явц / гарц / хүлээгдэж буй үр дүн/ гэсэн үе шаттай явагддаг. (4)

Энэ нь уламжлалт хичээлийн бүтцэт гэрийн даалгавар шалгах, өнгөрсөн хичээлийг давтах, шинэ хичээл үзэх, заасан хичээлээ бататгах, гэрийн даалгавар өгөх, хэсгүүдээс бүрддэг байсан (2) бол өнөөдөр өмнөх хичээлийг сэргээн санах, шинэ мэдлэг олгох, бататгах, дүгнэх үнэлгээ өгөх, хэсгүүдээс бүрдэн эдгээр нь эргэх холбоотойгоор явагдана. Гэвч багш нар хичээлийн төлөвлөлтийг өөрийн мэдлэг туршлагын түвшинд харилцан адилгүй боловсруулдагас, сургалтаар шийдвэрлэх асуудлууд, сургалтын элементүүд тэр бүр оновчтой хэрэгжиж чадахгүй байна (3). Үүнийг жил бүр зохион байгуулагддаг багш нарын ур чадварын уралдааны /БЗД/ сүүлийн 3 жилд оролцсон багш нарын дүнгээс харахад дараах дүгнэлтийг хийж болно.

- Багш хичээлийг төлөвлөн зохион байгуулж бэлтгэхдээ сурагчийн мэдлэгийн түвшинд бус, багшийн түвшинд бэлтгэдэг
- Хичээлийн сэдэв агуулгыг сонгох, мэдлэг бүтээх хэсгийг сурагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурладаггүй
- Хичээлийн цаг төлөвлөлтийг хангалтгүй тооцдог
- Ээлжит хичээлийн явцад үнэлгээг оновчтой зохион байгуулдаггүй
- Сурагчдад мэдлэг олгодог ч мэдлэг бүтээх үйл явц, дутмагаас хичээл үр дүн хангалт муутай гарах дутагдлууд гарч байна.

Технологийн хичээл, бусад ерөнхий эрдмийн хичээлүүдээс дор дурдсан онцлог шинж чанаруудтай (6). Үүнд:

- Сурагчдад олгож буй мэдлэг нь чадвар буюу хэрэглээ болох цогц чадамжаар хичээлийн үр дүн болон илэрдэг.
- Хичээлийн агуулгыг орон нутгийн онцлог материалын бололцоонд үндэслэн хувиргах боломжтой.
- Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд хичээлийн сэдвээс хамааруулан өргөн сонголттой.
- Мэргэжлийн чиг баримжаа олгох үндсэн хэрэглүүр болно.

Технологийн хичээлээр багш нар сургалтын үнэлгээг хэрхэн зохион байгуулж байгааг мэргэжлийн 286 багшаас судалгаа авч үзэхэд 70.8% нь ээлжит хичээлийн үнэлгээг бүтээлээр үнэлдэг гэсэн үзүүлэлт гарсан. Энэ бол технологийн хичээл дээр багш зөвхөн эдлэл зохион бүтээдэг нь үүнд нөлөөлсөн байж болно. Гэвч сурагчдаар хийлгэж буй эдлэл нь нь сурагчдын чадвараас ахадсан технологийн дарааллыг зөв тогтоож өгөөгүйгээс шаардлага хангахгүй эдлэл хийгдэх тохиолдол гардаг. Эсвэл тогтмол нэг төрлийн эдлэл хийдгээс сурагчдын бүтээлч сэтгэлгээг хязгаарлаж сонирхлыг бууруулснаар эдлэлийн чанар буурдаг тохиолдол бий. Гэхдээ дээр өгүүлсэн судалгаанд хамрагдсан багш нарын 70.8 хувь сурагчдын мэдлэгийг бүтээлээр үнэлжээ. Энд эдлэлийн чанар тааруу байсанд бус, сурагчдын техник технологи зохион бүтээх онолын мэдлэгийг орхигдуулж байсан гол дутагдал оршиж байгааг тэмдэглэж байна. Хамгийн гол зүйл технологийн ээлжит хичээлийн онолын мэдлэгийг шалгах, явцын үнэлгээг хийдэггүй нь судалгаанд хамрагдсан 200 сурагчийн ээлжит хичээлийн үр дүнд хийсэн бүтээлийн 60.4% нь эдлэлд тавигдах шаардлагыг бүрэн хангахгүй үнэлгээ авч байгаагаас харагдаж байна. Технологийн хичээлээр сурагчид бүтээлдээ дараах шаардлагыг хангаснаар Эдийн засгийн боловсролыг бүрэн олж авна. Үүнд:

- Эдлэлийг зургийн дагуу эд ангиудын тоо ширхгийг гаргах.
- Тэдгээрийн материалыг сонгох.
- Орох материалуудын тооцоог гаргах.
- Материалыг хэмнэлттэй зарцуулж, хэмжээ тавьж эсгэх.

- Эдлэлийн нийт үнийн тооцоог гаргах.
- Эдлэл борлуулах тооцоог гаргах гэсэн үзүүлэлтүүд орно.

Дүгнэлт

Өнөөгийн иргэний нийгэмд бид ерөнхий боловсролын сурагчдад авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал хөдөлмөрт тасралтгүй суралцах амьдрах ухааны боловсрол Төлөвшүүлэхэд (1) технологийн хичээлийн ач холбогдол улам нэмэгдсээр байна. Харин сурагчдад технологийн хичээлийн онолын мэдлэгийг бүрэн сайн эзэмшүүлэх ажлыг багш зөв чиглүүлж, чадвал сургалтын гарц үр дүнтэй байх нь зайлшгүй юм. Ингэж чадвал бид сурагчдад амьдрах ухааны болон эдийн засгийн боловсролыг зөв оновчтой олгож чадна. Иймд ээлжит хичээлийн онолын мэдлэгийг үнэлэх явцын үнэлгээ нь хүүхдийн хөгжилд нөлөөлөх чанарын өөрчлөлт бөгөөд сурагчдыг чадваржуулах гол хүчин зүйл гэж үзэж байна.

Ном зүй:

1. Боловсролын тухай хууль. УБ. 2007 он.
2. Батхуяг.С нар “Сурган хүмүүжүүлэх үндэс” УБ. 2003 он.
3. Жадамба.Б. “Сургуулийн хөгжлийн онол” УБ. 2004 он.
4. Ичинхорлоо. Ш. “Сургалт” УБ. 2008 он.
5. Технологийн боловсролын стандарт . УБ. 2004 он.
6. Хөхөө.Д. “Сурагчдыг үнэлж дүгнэх, үйл ажиллагааны чиг хандлага” УБ. 2000 он.